





Хөргөгч хөлдөөгч

ашиглалтын заавар

Загвар: CF-100MW

CF-100MW

CF-100MW

Бүрэлдэхүүн хэсэг**Байрлуулах заавар**

нь хана болон бусад тавилганаас 10 см зайтай байхаар байрлуулна Хөлдөөгчийг хэрэглэхээс өмнө дотоод болон гадаад савлагаанаас салгана. Дагалдах иж бүрдэл бүрэн байгаа эсэхийг шалгах. Үүнд:


- 1 Хадгалах сагс
- 1 Тусгаарлагч
- 1 Ашиглалтын заавар
- 1 Хуванцар хусуур
-

Хөлдөөгчийг цахилгааны эх үүсвэрт залгахаас өмнө босоо байрлалд 4 цаг байлгах хэрэгтэй. Энэ нь хөргөх системд тээврийн явцаас үүдэн үүсэх ямар нэгэн эвдрэлийг бууруулах боломжийг олгодог. Мөн бүлээн усанд базсан зөөлөн арчуураар дотор талыг сайтар цэвэрлэнэ

Хөлдөөгчийг байрлуулах

Энэ бүтээгдэхүүн нь босоо байдалд байхаар зориулагдсан ба ямар нэгэн тавилга дотор суурилуулахгүй байх хэрэгтэй Хөлдөөгчийг дүүрэн байгаа үед нь ямар нэгэн асуудалгүйгээр даах тэгш гадаргуу бүхий шалан дээр байрлуулна.

Хөлдөөгчийг хажуу, ар талаас



Хөлдөөгчийг нарны гэрэл шууд тусдаг газарт болон ямар нэгэн халдаг төхөөрөмжөөс (зуух, халаагч, гэх мэт.) хол байрлуулна.

Нарны шууд тусгал нь дулаан тусгаарлагч хөвөнд нөлөөлөн халалтыг ихэсгэн халаагч элементүүд цахилгаан ихээр зарцуулна.

Хэтэрхий хүйтэн орчин нь хөлдөөгчийн зохистой ажиллагаанд сөргөөр нөлөөлнө.

Хөлдөөгчийг чийгтэй орчинд байрлуулахгүй байх.

Хөлдөөгчийг дан ганцаар нь нэг залгуурт залгах хэрэгтэй ба залгуур нь газардуулгад холбогдсон байвал зохино.

Тэжээлийн залгуурын газардуулах хэсгийг тайран авахыг хориглоно.

Цахилгаан болон газардуулгатай холбоотой ямар нэгэн асуулт болон үйлчилгээ нь мэргэжлийн цахилгаанчин болон баталгаат засварын төвийн зааварчилгаагаар хийгдэнэ.

Хөлдөөгчийг цахилгаанд залгаснаас 2-3 цагийн дараа хөлдөөх хүнсийг хийж эхэлнэ.

Хөлдөөгчийг ажиллуулах


Температурын тохиргоо

Хөлдөөгч нь температур тохируулах хянагчтай ба энэ нь хөлдөөгчийн баруун доод буланд байрлаж байгаа. Температурын тохиоргоо нь 1 – 5 ийн хооронд байгаа ба 5 нь хамгийн хүйтнээр тохируулна. Энэ сонголтоос та өөрийн шаардлагатай байгаа хэмжээндээ тохируулан тааруулж

болно. 4 тохиргоон дээр байрлуулах нь гэрийн болон албан газрын хэрэглээний нөхцөлд тохиромжтой. 5 тохиргоо нь хөлдөөгчийг хамгийн хурдан хөлдөөх горимд оруулах ба таныг энэ тохиргоог буцаан өөрчлөхөөс нааш тохиргоо идэвхитэй

хэвээрээ байна.

Хөлдөөгчийг унтраахийн тулд тохиргоог "OFF" горимд шилжүүлнэ.



Анхааруулга:

Тохиргоог "OFF" горимд шилжүүлснээр зөвхөн хөлдөөх ажиллагаа л зогсоно. Харин хөлдөөгчийн цахилгаан зарцуулалтыг унтраахгүй болохыг анхаарна уу.

Хөлдөөгч нь залгуураас салах, цахилгаан тасрах, унтрах зэрэг байдалд орсны дараа дахин асаахын тулд та 5 минут хүлээх хэрэгтэй. Энэ хугацаанаас өмнө хөлдөөгч дахин асахгүй.

Их хэмжээний хүнс хийх нь хөлдөөгчийн хөргөөх үйл ажиллагааг бууруулна. Хэрэв та хөлдөөгчийн температурыг тохируулахаар шийдвэл нэг удаагийн тохиргоогоор нэг л тоон дээр тохируулах хэрэгтэй. Энэ тохируулсан тохиргооны температур хүртэл хөрөхөд хэдэн цаг хэрэгтэй.

Хөлдөөгчийг гэсгээх


ХЭЗЭЭ? Хөлдөөгч үр ашигтай ажиллах, цахилгаан бага зарцуулах үүднээс түүний ханад хуримтлагдсан мөсийг 5-10 мм зузаан тогтсон үед хайлуулан ховхлох хэрэгтэй.

Хөлдөөгч доторх хөлдөөх хүнс бага байгаа үеийг сонгож цэвэрлэгээ болон гэсгээлтийг хийх хэрэгтэй.

Анхаар

Буцламгай халуун ус хийхгүй байх. Нэмж хэлэхэд, Мөсийг ховхлохдоо төмөр болон хурц иртэй зүйл хэзээ ч хэрэглэж болохгүй ба энэ нь хөлдөөгчийн доторхи ханын хөлдөөх элементийг гэмтээнэ. Энэ тохиолдолд баталгаат засвар хүчингүйд тооцогдоно. Та хөлдөөгчинд дагалдан ирэх хуванцар хусуурыг ашиглана уу.

- Хөлдүү байгаа хүнсийг хөлдөөгчнөөс авч, хүнсийг хамгаалах үүднээс сэрүүн газар байлгана.
- Тохиргоог "OFF" горимд шилжүүлнэ
- Хөлдөөгчийг цахилгаанаас салгана. / Ногоон гэрэл унтарна /
- Гэсгээж байх хооронд хөлдүү мөснүүд хананаас салж ховхорно.
- Хөлдөөгчийн доод ёроолд байгаа зайлуулах тосгуурыг тэгш хэмээр дээш нь гарган авна
- Хөлдөөгчийн дотор, гадна талын ус зайлуулах тагийг нээхэд гэссэн ус түүгээр гадагшилна.
- Ус тосох савыг хааяа шалгаж байх нь ус дүүрэхээс сэргийлнэ.
- Хөлдөөгчийн дотор талыг цэвэрлэнэ.
- Дотор талын тагийг буцаан таглана.
- Температурыг буцаан тохируулна
- Нэг цагийн турш хүнс хийлгүйгээр ажиллуулна
- Хүнсийг буцаан хийнэ



Хөлдөөгчийн ус зайлуулах тагийг авах дараалал

Тустай санамж:

Гэсгээх нь ихэвчлэн хэдэн цаг үргэлжилнэ. Хаалгыг нээн гэсгээх нь мөс хайлах хугацааг түргэсгэнэ. Мөн бүлээн ус гоожуулах нь мөс хайлах хугацааг хурдасгана. Хэрэв та хусуур хэрэглэх бол маш болгоомжтой ашиглах хэрэгтэй. Энэ нь хөргөгчийн дотор ханын хөргөөх элементийг амархан эвдэх магадлалтай байдаг.

Хөлдөөгчийн хэсэг

Энэ хэсэгийг хүнсийг удаан хугацаанд хөлдүү хадгалах зориулалтаар зохион бүтээсэн. Хадгалах хугацаа нь 3 хүртэл сар байна.

Хүнсний төрлөөс хамааран түүнийг хөлдүү хадгалах хугацаа нь харилцан адилгүй байх ба уг заасан хугацаанаас нь хэтрүүлэх хэрэггүй.

Хөлдөөгчийг гэсгээх үед хүнсийг хэрхэн хадгалах тухай зааврыг дагах хэрэгтэй.

Урьдчилан савлан хөлдөөсөн хүнсийг хөлдөөгчинд хадгалахдаа түүнийг үйлдвэрлэсэн үйлдвэрлэгчийн хадгалах зааврыг дагах хэрэгтэй.

Хөлдүү хүнсийг худалдан авсны дараа байж болох хамгийн хурдан хугацаанд буцаан хөлдөөгчигд хийх хэрэгтэй.

Мөс ихээр хуримтлагдсанаас үүдэн хөлдөөгчийн хаалга амархан эвдрэх магадлалтай. Ийм мөсийг 5-10 мм зузаан хуримтлагдсан даруй хайлуулж байх хэрэгтэй.

Хадгалах сагсанд мохоо ирмэгтэй зүйлсийг хийнэ. Хөлдөөгч дэх бусад хүнсийг авахын тулд , сагсыг хажуу тийш нь зайлуулах, эсвэл дээш нь өргөн авах хэрэгтэй.

Арчилгаа болон засвар үйлчилгээ**Хөлдөөгчийг цэвэрлэх**

Хөлдөөгчийг худалдан авснаас хойш тогтмол хугацаанд цэвэрлэгээ хийж байх хэрэгтэй.

Температурын тохиргоог "OFF" горимд шилжүүлэн хөлдөөгчийг тэжээлээс салгаж хүнс болон сагсыг гарган авна.

Дотор талыг цэвэрлэхдээ хүнсний содтой бүлээн усаар чийглэсэн зөөлөн даавуугаар арчна. 450 грамм усанд 2 амны халбага хүнсний сода хийхэд болно.

Сагсийг бага зэргийн угаалгын нунтагтай усаар угаана.

Хаалганы жийрэг резинийг цэвэрхэн байлгах хэрэгтэй ба энэ нь хөлдөөгчийн идэвхитэй ажиллагаанд нөлөөлдөг.

Хөлдөөгчийн гадна талыг цэвэрлэхдээ бага зэргийн угаалгын нунтагтай бүлээн усаар угааж цэвэрлэнэ.

Дотоод, гадаад талыг хаттал нь сайн арчна.

Конденсацийн ороомгууд бохирдсон болон шороо дарсан бол вакуумдан далдлах хэрэгтэй. Хөлдөөгчийг гэсгээх бүртээ цэвэрлэгээ хийж байх нь үнэр тогтохоос сэргийлэн зохистой ажиллагааг хангана.

Амралтын хугацаа

Хүнсийг гаргана

Хөлдөөгчийг тэжээлээс салгана

Хөлдөөчийг цэвэрлэнэ.

Хөлдөөгч дотор үнэр орохоос сэргийлэн хаалгыг нь бага зэрэг онгойлгон орхино.

Хүүхдүүд тоглох зориулалтгүй тул хүүхдүүд үүгээр тоглохоос маш сайн хамгаалах хэрэгтэй. Богино хугацааны амралт: Гураваас бага 7 хоногоор аялахаар бол хөргөгчийн ажиллагааг зогсоох шаардлагагүй

Урт хугацааны амралт: Хэрэв хэдэн сарын турш ажиллуулархааргүй бол бүх хүнсийг гаргаад хөлдөөгчийг тэжээлээс салгана. Дотор талыг сайн цэвэрлэнэ. Үнэр болон мөөгөнцөрдөхөөс сэргийлэн хаалгыг бага зэргийн нээлттэй орхино.

Хөлдөөгчийн байрыг солих

Хүнсийг гаргана.

Хөлдөөгчийн дотор байгаа бүх үлдэгдэл зүйлсийг гаргана.

Дугуйнуудыг салгаж авна.

Хаалгыг хаана

Тээвэрлэлтын явцад босоо байрлалд авч явна

Эрчим хүч хэмнэх

Хөлдөөгчийг өрөөний хамгийн сэрүүн газарт янз бүрийн халах төхөөрөмжүүдээс хол, нарны гэрэл тусахааргүй газарт байрлуулна.

Халуун хүнсийг хөргөсний дараа хөргөгчинд хийнэ. Их хэмжээний хүнс хийх нь хөлдөөгчийн ажиллах ачааллыг ихэсгэнэ. Удаан хугацаанд хөлдөөх үед хүнс өөрийн эрүүл байдлаа бага хэмжээнд алдаж болзошгүй.

Савлагаатай хүнсийг зохистой хадгалах хэрэгтэй. Эдгээрийг хөлдөөгчинд хийхээс өмнө хөлдөөгчийн дотор талыг сайн цэвэрлэн хуурай болтол арчих хэрэгтэй. Ингэснээр хөргөгчийн дотор хананд мөс тогтохыг багасгана.

Хөлдөөгчийн дотор ямар нэгэн мөнгөлөг цаас, цаасан ороомогт боосон хүнс хийх нь доторхи хүнсийг хөлдөөх агаарын солилцоог багасгаад зогсохгүй зохистой ажиллагаанд нь сөргөөр нөлөөлнө.

Хүнсийг эрэмбэ дараалалтайгаар байрлуулах нь түүнийг хайж олох болон хаалгыг удаан нээлттэй байхаас зайлсхийнэ. Хаалгыг нэг удаа онгойлгож өөрт хэрэгтэй байгаа зүйлээ нэг зэрэг авч хаалгыг нэн даруй хаах хэрэгтэй.

Тулгарсан асуудлыг шийдвэрлэх

Хөлдөөгчинд тулгардаг түгээмэл асуудлуудыг засварын төвд төлөх нэмэлт зардалгүйгээр хялбархан шийдвэрлэж чадна. Доор өгөх зөвлөгөөг засварчин дуудахаасаа өмнө туршаад үзээрэй.

Гарч болзошгүй асуудал

Асуудал	Асуудлын шалтгаан
Хөлдөөгч ажиллахгүй байх	Тэжээлд залгагдаагүй. Гал хамгаалагч шатсан. Хөлдөөгчийн температур "OFF" байрлалд байх.
Мотор тогтмол хугацаанд асаж унтрах .	Өрөөний дулаан хэвийн хэмжээнээс их Их хэмжээний хүнс хөлдөөгчинд хийсэн. Хаалга хэтэрхий удаан онгорхой байсан. Хаалга гүйцэд хаагдаагүй. Температурын тохиргоо зохистой таараагүй. Хаалганы резин гүйцэд наагдаагүй Хөлдөөгчийг зохистойгоор цэвэрлээгүй Хөлдөөгч тодорхой хугацааны турш тэжээлээс салсан байсан. Хөлдөөгч хөртлөө 4 хүртэл цаг шаардлагатай
Хөлдөөгчийн доторхи температур хэтэрхий дулаан.	Температурын тохиргоог хэтэрхий дулаан градус дээр тохируулсан. Температурын тохиргоог бага зэрэг хүйтэн тохируулан хэдэн цагийн турш хүлээх хэрэгтэй. Хаалга нээлттэй удсан ба олон удаа нээж хаасан. Хаалга нээх хаах тоолонд халуун агаар хөлдөөгч дотор нэвтрэн ордог. Хаалгыг бага онгойлгох хэрэгтэй Хаалга бүрэн хаагдаагүй.. Их хэмжээний хүнсийг хөлдөөхөөр хийгээд удаагүй байгаа. Тохируулсан температуртаа хүртэл хөргөөх цагийг олгон хүлээх хэрэгтэй Хөлдөөгч тодорхой хугацааны турш тэжээлээс

.	салсан байсан. Хөлдөөгч хөртлөө 4 хүртэл цаг шаардлагатай
Хөлдөөгчийн доторхи температур хэтэрхий хүйтэн.	Температурын тохиргоог хэтэрхий бага градус дээр тохируулсан. Температурын тохиргоог бага зэрэг дулаан тохируулан хэдэн цагийн турш хүлээх хэрэгтэй.
Мотор асах үед ус гүйх болон шаржигнан дуугарах чимээ гарах.	Халуун усны хоолойгоор ус гүйж байгаа чимээ ба энэ нь энгийн юм. Хөлдөөгч ажиллаад эхлэх үед энэ чимээ алга болдог.
Ус буцалж байгаа мэт чимээ гарах.	Хөлдөөгч бодис системийн дотор урсаж байна. Энэ бол энгийн
Чичиргээ	Хөлдөөгчийн тэнцвэртэй байлыг шалгах. Шал нь тэгэш бус хазгай эсэхийг шалга. Хөлдөөгч нь зөөвөрлөх үед шалан дээр догонцох. Шал нь хөлдөөгчийг сайн тулж байгааг шалгах. Хөргөгчийн хөл доор мод болон ямар нэгэн төмөр зүйлийг тулах байдлаар тэнцвэржүүлэх хэрэгтэй.
Хөлдөөгчийн дотор хана чийгших	Агаар халуун болон чийгшилтэй байх. Энэ нь хэвийн юм Хаалга дутуу хаагдсан. Хаалга удаан хугацаанд нээлттэй байсан. Хаалгыг бага онгойлгох хэрэгтэй. Хаалганы чииргэвч резин муудсан.
Хөлдөөгчийн гадна хана чийгших	Хаалга дутуу хаагдан хүйтэн агаар хөлдөөгч дотроос гарч гадна талд чийгшил үүссэн
Хаалга сайн хаагдахгүй	Хөлдөөгч тэгш биш Хаалганы чииргэвч резин бохир Хадгалах сагс зөв хийгдээгүй